

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

Код: СТ-16/401

МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН (Мэдээлэл лавлагаа)

Гүйцэтгэсэн судлаач:

Ц.Норовдондог

Ц.Болормаа

Ч.Онончимэг

Д.Халиун

Д.Жигваагүнсэл

Б.Нандингэрэл

Улаанбаатар

2015 он

МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Өнөөгийн байдлаар Монгол улсад хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны хүрээнд ерөнхий зохицуулалтын 30, салбарын зохицуулалтын 34 хууль үйлчилж байна. Мөн хөрөнгө оруулалтыг дэмжих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд батлан гаргасан УИХ-ын тогтоол 14, Засгийн газрын тогтоолоор баталсан журам 29 хүчин төгөлдөр үйлчилж байна. /Лавлагаа хавсаргав/.

2013 онд **Хөрөнгө оруулалтын тухай хууль** батлагдсан гарсанаар “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”, “Стратегийн ач холбогдолтой аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль” хүчингүй болж, хөрөнгө оруулагчдыг дотоод, гадаадын хөрөнгө оруулагч гэж ялгаварлалгүйгээр төрөөс тэгш, шударга дэмжих эрх зүйн орчин бүрдсэн гэж хэлж болно.

“Хөрөнгө оруулалтын тухай” хуульд зааснаар хөрөнгө оруулалтын дараахь хэлбэрүүд байна. /5-р зүйл / Үүнд:

- Хөрөнгө оруулагч дангаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;
- Хөрөнгө оруулагч хувьцаа, өрийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах;
- Компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;
- Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;
- Санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх
- Хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалт

Түүнчлэн, хөрөнгө оруулалт нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт гэсэн ерөнхий хэлбэртэй бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт нь *шууд ба шууд бус*, дотоодын хөрөнгө оруулалт нь *төсвийн болон концессийн хөрөнгө оруулалт* хэлбэртэй байхаар хуульчилсан.

Хуулийн 5 дугаар бүлгийн 20 дугаар зүйлд зааснаар **500 тэрбум төгрөгөөс** дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай хүсэлт гаргасан тохиолдолд үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахаар заасан.

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд /21-р зүйл/ уул уурхай, банк санхүү, хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмшихээр бол хуулиар тогтоосон зохих шалгуурыг хангаж Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авахаар хуульчлан тогтоосон байдаг.

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд гэдэгт нийт гаргасан хувьцааных нь 50, түүнээс дээш хувийг гадаад улсын төр шууд болон шууд бусаар эзэмшиж байгаа хуулийн этгээдийг ойлгохоор хуульчилсан байна.

Түүнчлэн, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн бас нэгэн шинэлэг зохицуулалт нь “Тогтворжуулах гэрчилгээ” буюу татварын орчны тогтворжуулалт юм. Энэ нь 16 дугаар зүйлд зааснаар татварын орчинг тогтворжуулахад дараахь шалгуур тавигдаж байна.

- **Уул уурхайн олборлолт, хүнд үйлдвэр, дэд бүтцийн салбарт** хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан дараах хугацаагаар татварын орчныг тогтворжуулна Үүнд:

Хөрөнгө оруулалтын хэмжээ <i>/тэрбум төгрөгөөр/</i>	Хөрөнгө оруулалт хийж дуусах хугацаа <i>/жилээр/</i>					
	Улаанбаатарын бүс	Төвийн бүс Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Төв	Хангайн бүс Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай Хөвсгөл	Зүүн бүс Дорнод, Сүхбаатар, Хэнтий	Баруун бүс Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд	Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа <i>/жилээр/</i>
30-100 хүртэл	5	6	6	7	8	2
100-300 хүртэл	8	9	9	10	11	3
300-500 хүртэл	10	11	11	12	13	4
500-аас дээш	15	16	16	17	18	5

- **Уул уурхайн олборлолт, хүнд үйлдвэр, дэд бүтцээс бусад салбарт:**

Хөрөнгө оруулалтын хэмжээ <i>/тэрбум төгрөгөөр/</i>	Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа <i>жилээр</i>	Хөрөнгө оруулалт хийж дуусах хугацаа <i>жилээр</i>				
		Төвийн бүс Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/	Хангайн бүс /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/	Зүүн бүс /Дорнод, Сүхбаатар, Хэнтий/	Баруун бүс /Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/	
Улаанбаатарын бүс						
10-30 хүртэл	5-15	4-12	3-10	2-8	5	2
30-100 хүртэл	15 -50	12-40	10-30	8-25	8	3
100-200 хүртэл	50 -100	40-80	30-60	25-50	10	4
200-аас дээш	100-аас дээш	80-аас дээш	60-аас дээш	50-аас дээш	15	5

Түүнчлэн дараах төслийг хэрэгжүүлэх тохиолдолд тогтворжуулах гэрчилгээний хугацааг дээр заасан хугацаанаас 1.5 дахин уртасган тооцохоор заасан. Үүнд:

- Улс орны нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд онцгой ач холбогдол бүхий импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан өдрийн Төв банкны албан ханшаар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх тооцоотой, бүтээн байгуулалтын ажилд гурваас дээш жил шаардагдах төслийг байршил, салбар харгалзахгүйгээр;
- Хуулийн 16.1-д заасан шалгуурыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээд нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэл эрхлэн, үндсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргаж байгаа;

Монгол улсад хөрөнгө оруулж буй тохиолдолд дараахь татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх ээр хуульд заасан. /ХОТХ, 10-р зүйл/ Үүнд:

Татварын дэмжлэг:

- Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх, татвар ногдох орлогоос элэгдлийн зардлыг хасах, алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох, ажилтны сургалтын зардлыг татвар ногдуулах орлогоос хасч тооцох гэх мэт.
- Импортын техник, тоног төхөөрөмжийг тодорхой нөхцөлд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг тэглэх хүртэл арга хэмжээ авах

Татварын бус дэмжлэг /12-р зүйл/

- Газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах;
- Чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах тохиолдолд бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсөн горимоор үйлчлэх;
- Дэд бүтэц, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоог нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох;
- Инновацийн төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилтэд батлан даалт гаргах;
- Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрөл олгох гэх мэт.

Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсанаар хөрөнгө оруулалтын орчинд дараах эерэг өөрчлөлт гарсан гэж зарим судлаачид үзсэн байна.

1/ Тогтворжуулах гэрчилгээ: Хөрөнгө оруулалтын тухай хуулийн зарчмын үндсэн том өөрчлөлтийн нэг нь Тогтворжуулах гэрчилгээ олгох замаар татварын орчныг тогтворжуулах зохицуулалт хийсэн. 1993 онд баталсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд Тогтвортой байдлын гэрээг хөрөнгө оруулагчидтай байгуулахаар заасан

байдаг. Энэхүү Тогтвортой байдлын гэрээг Тогтворжуулах гэрчилгээгээр сольсон бөгөөд гэрээгээр биш хуулиар тогтвортой байдлыг бий болговол хөрөнгө оруулж байгаа болон хөрөнгө оруулалт татаж байгаа аль аль талдаа ашигтай юм. Энэ бодлого Хөрөнгө оруулалтын тухай хуульд шингэж, “Тогтворжуулах гэрчилгээ” гэсэн шинэ нэр томъёо орж ирсэн байна.

2/ Тогтвортой байдлын гэрээ: 1993 онд батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд Монгол Улсад 20 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс доошгүй хэмжээний хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээ байгуулах тухай заасан байдаг. Харин энэ хуулиар тогтвортой байдлын гэрээг “Тогтворжуулах гэрчилгээ” болгосноор хөрөнгө оруулагчид 4 төрлийн татварын орчныг тогтвортой байлгахаар хуульчилсан нь тус зохицуулалт урт хугацаанд тогтвортойгоор үйлчлэх байх гэсэн итгэлийг хөрөнгө оруулагчдад өгч, улмаар аль ч хөрөнгө оруулагч нарт эрх зүйн таатай нөхцлийг бүрдүүлсэн юм.

3/ Тогтворжуулах гэрчилгээний шалгуур, хязгаарлалт:-ыг хуульчлан тогтоож өгсөн. Ингэснээр 10 сая долларын хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж болгон Тогтворжуулах гэрчилгээ авах боломжгүй болох бөгөөд хөрөнгө оруулах нөхцөл бодитоор дээшилсэн байна. Тогтворжуулах гэрчилгээ авахад байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх, шинээр ажлын байр бий болгох, шинэ техник технологи нэвтрүүлж буй эсэхийг харгалзан үзнэ. Эдгээр шалгуурыг хангасан хөрөнгө оруулагчдад Тогтворжуулах гэрчилгээ олгоно. Тогтворжуулах гэрчилгээний давуу тал нь гэрчилгээ олгосон үндэслэл нээлттэй ил тод байна.

4/ Хөрөнгө оруулалтын гэрээ: Хөрөнгө оруулалтын гэрээ хийх эрх бүхий хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын босгыг өндөр болгосноор хөрөнгө оруулалтаас үүсэх мөнгөн урсгалын хэмжээ ихсэж, эдийн засагт эерэгээр нөлөөлөх нөхцөл бүрдсэн. Хөрөнгө оруулалтын гэрээг гадаадын хөрөнгө оруулагчтай ихэвчлэн хийдэг байсан бол Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаад, дотоод хөрөнгө оруулагч гэж ялгахгүй бөгөөд зөвхөн 500 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийсэн ямар ч хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын гэрээ хийх боломжтой болсон. Дотоодын хөрөнгө оруулагчдад ижил тэгш хандаж байгаа энэ бодлогыг үндэсний компаниудаа дэмжих том бодлого хэмээн компаниуд хүлээн авч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

5/ Тогтвортой байдлын гэрчилгээ олгох субъектийг хуулиар тусгайлан заасан: Тогтворжуулах гэрчилгээг олгох эсэхийг шийдвэрлэх гол байгууллага нь шинээр байгуулагдах Хөрөнгө оруулалтын зөвлөл. Уг зөвлөл Тогтворжуулах гэрчилгээ авахыг хүссэн аж ахуйн нэгж, төслийг хянаж гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэхээс гадна гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа явуулах эсэхэд зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий байнгын бус ажиллагаатай байгууллага юм. Зөвлөлөөс зөвшөөрсөн тохиолдолд хөрөнгө оруулалт хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Тогтворжуулах гэрчилгээг олгох юм.

6/ Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалт хийх: Түүнчлэн гадаадын төрийн өмчит хуулийн этгээд Монгол улсад хөрөнгө оруулалт хийх тохиолдолд хяналт болон үндэсний аюулгүй байдлын бусад харилцааг харгалзан үзэж тодорхой зохицуулалт хийсэн байна. Үүнд: Уул уурхай, банк санхүү, хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх, Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар заасан нь үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдлыг хангахад ач холбогдол бүхий зохицуулалт болсон.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийг батлан гаргахад дараах нөхцөл байдлуудыг харгалзан үзэх шаардлагатай байсан гэсэн шүүмжийг хэлэлцүүлгийн явцад судлаач, нийтлэлчдийн зүгээс гарган тавьж байсан. Үүнд:

Судлаачдын зүгээс Хөрөнгө оруулалтын хуульд зохицуулаагүй орхисон, хэт ерөнхийлсөн санаа байна гэж шүүмжилдэг. Тухайлбал:

- Тогтворжуулалтын гэрчилгээ олгохоос татгалзах үндэслэл тодорхой бус
- “нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэл” гэж яг юуг ойлгох тухай тодорхой тусгах шаардлагатай.
- Зөвхөн 4 төрлийн татварыг л тогтворжуулахаар заасан нь экспортын татвар, онцгой албан татвараар хөрөнгө оруулагчдыг дарамтлахад хүргэх вий гэсэн болгоомжлол төрүүлж болох,
- Хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэгийн тухай зарим заалт нь иргэний нийгмийн байгууллагыг болгоомжлоход хүргэж байна. Тухайлбал:
 - газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 жил хүртэл хугацаагаар сунгах,
 - гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох,
 - чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсэн горимоор үйлчлэхээр заасан нь иргэний нийгмийн зүгээс ихээхэн шүүмжлэл дагуулдаг.

2. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зохицуулалт

Түүнчлэн дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжиж үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг сайжруулах, үнэ цэнэ шингэсэн байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаа бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэх, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэх зорилгоор 2015 оны 7 сард Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль баталсан болно.

Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг УИХ-аар 2015 оны 07 сарын 29-ны өдөр хэлэлцэн баталсан бөгөөд тус хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт тарьж ургуулсан, өсгөж үржүүлсэн, олборлосон, эсхүл импортын түүхий эдээр үнэ цэнэ шингээж боловсруулалт хийсэн экспортын чиг баримжаатай, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих харилцааг зохицуулсан болно.

Өөрөөр хэлбэл, Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээд мөн ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах үйл ажиллагааг дээрх дэмжлэгт хамааруулаагүй болно.

Төрөөс үйлдвэрлэлийг дэмжих хэлбэрийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үндэсний үйлдвэрт технологийн шинэчлэл хийсэн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөд зориулан арилжааны банкнаас олгосон зээлийн хүүгийн зөрүүг олгох;

2. Өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи болон өндөр технологи бий болгон, нэвтрүүлж нутагшуулсан экспортын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх

хугацаанд судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг нэг удаа улсын төсвөөс тухайн үйлдвэрт буцааж олгох;

3. Экспортын үйлдвэрлэлийг экспортын санхүүжилтийн төрөл бүрийн арга хэрэгсэл, түүний дотор факторингийн үйлчилгээг хөгжүүлэх замаар дэмжих зэрэг болно.

Дээрх дэмжлэгийг Үйлдвэрлэлийг дэмжих сангаар дамжуулан дотоодын түүхий эд болон импортын түүхий эдийн нөөцөд тулгуурлан үнэ цэнийн сүлжээг бий болгосон нөхцөлд олгох ба дараах шаардлагыг хангасан бол давуу эрх олгохоор тусгажээ. Үүнд:

- *нээлттэй хувьцаат компани байх;*
- *үйлдвэрлэлийн үндсэн болон туслах материал, бусад хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээний 60-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэгчээс хангасан байх;*
- *технологийн бүртгэлийн нэгдсэн санд бүртгэлтэй байх.*

Үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгө нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, олон улсын байгууллага, гадаад улсаас үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон зээл, олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив, тусламж зэргээс бүрдэх ба уг улсын төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилахаар хуульчилсан байна.

**МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛЖ БУЙ ГОЛ ХУУЛИУД**

№	Огноо	Хуулийн нэр	Нэмэлт өөрчлөлт орсон огноо
1.	2002-01-10	Иргэний хууль	2015-07-02
2.	2013-10-03	Хөрөнгө оруулалтын тухай хууль	2015-05-14
3.	2013-10-03	Хөрөнгө оруулалтын сангийн тухай	-
4.	2011-10-06	Компанийн тухай хууль	2015-06-19
5.	2010-01-28	Концессийн тухай хууль	2015-10-30
6.	2008-05-20	Татварын ерөнхий хууль	2015-07-09
7.	2006-07-08	Ашигт малтмалын тухай хууль	2015-06-04
8.	2001-02-01	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	2015-08-07
9.	2006-06-29	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	2015-06-04
10.	2001-04-12	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль	2015-02-12
11.	2012-05-17	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2015-01-23
12.	2008-05-20	Гаалийн тухай хууль	2015-05-29
13.	2008-05-20	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль	2014-07-01
14.	2005-07-01	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль	2013-02-07
15.	2014-07-01	Газрын тосны тухай хууль	2015-07-09
16.	2011-02-10	Монгол улсын хөгжлийн банкны тухай хууль	2014-10-16
17.	2015-07-09	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль	-
18.	2006-06-29	Онцгой албан татварын тухай хууль	2015-10-30
19.	2015-02-18	Өрийн удирдлагын тухай хууль	2015-10-30
20.	2006-06-22	Санхүүгийн түрээсийн тухай хууль	-
21.	2010-06-24	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль	2015-11-10
22.	2011-12-23	Төсвийн тухай хууль	2015-11-10
23.	2009-06-25	Улсын бүртгэлийн ерөнхий хууль	2015-11-13
24.	2015-07-09	Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	-
25.		Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль	
26.	2010-01-21	Хөрөнгийн үнэлгээний тухай хууль	-
27.	2011-06-02	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль	2015-11-10
28.	2010-04-23	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль	-
29.	2015-01-29	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль	-
30.	2015-02-12	Чөлөөт бүсийн тухай хууль	-

**МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ЗОХИЦУУЛЖ БУЙ
ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИУД**

№	Огноо	Холбогдох хуулийн нэр	Нэмэлт өөрчлөлт орсон огноо
1.	1998-01-02	Авто замын тухай хууль	2014-05-15
2.	2012-05-17	Агаарын тухай хууль	2015-11-13
3.	2010-06-24	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль	2015-11-13
4.	2015-06-19	Аудитын тухай хууль	-
5.	2000-05-05	Аялал жуулчлалын тухай хууль	2011-01-20
6.	2012-05-17	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	-
7.	1995-03-30	Байгаль орчныг хамгаалах тухай	2015-07-08
8.	2010-01-28	Банкны тухай хууль	2015-07-09
9.	2008-02-05	Барилгын тухай хууль	2015-07-02
10.	2003-05-30	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай	2014-10-31
11.	2002-06-07	Газрын тухай хууль	2015-07-08
12.	1997-04-24	Газрын төлбөрийн тухай хууль	2012-05-22
13.	1988-11-29	Газрын хэвлийн тухай хууль	1995-04-17
14.	2009-07-16	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай	-
15.	2007-07-27	Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль	2015-01-29
16.	2012-02-10	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль	-
17.	2011-10-20	Зээлийн мэдээллийн тухай хууль	-
18.	2012-05-22	Инновацийн тухай хууль	2015-01-23
19.	2002-06-27	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль	2012-05-18
20.	1994-05-31	Нийгмийн даатгалын тухай хууль	2015-01-30
21.	2015-06-19	Нийслэл хотын албан татварын тухай	-

22.	2015-06-19	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	-
23.	2010-06-10	Өрсөлдөөний тухай хууль	2015-06-19
24.	2008-02-06	Татварын өршөөл үзүүлэх тухай хууль	2008-05-09
25.	2005-12-01	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль	2015-07-09
26.	2014-01-09	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	-
27.	2012-05-17	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	-
28.	2012-05-17	Усны тухай хууль	2012-08-17
29.	2002-11-07	Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай	2011-10-28
30.	2008-05-29	Хот байгуулалтын тухай хууль	2015-06-26
31.	2006-06-16	Хувь хүний орлогын албан татварын тухай	2015-07-09
32.	2009-11-18	Хүний хөгжил сангийн тухай	2015-05-21
33.	1995-01-16	Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай	-
34.	2003-06-19	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль	2011-10-20

Хавсралт 2

Хөрөнгө оруулалтын бодлого зохицуулахтай холбоотой УИХ-ын тогтоол

№	Тогтоолын дугаар	Баримт бичгийн нэр	Огноо
1.	51	Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг батлах тухай	2015.05.22
2.	87	Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалын тухай	1995 .12 .4
3.	57	Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай	2001. 6.14
4.	24	Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай	2003.06.12
5.	64	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай	2009-10-15

6.	62	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	2015-06-19
7.	65	Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого батлах тухай	2011-12-23
8.	34	Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	2010-06-24 2012-08-17
9.	29	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай	2003-06-18
10.	18	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай	2014-01-16
11.	54	Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай	2003.12.11
12.	29	ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ /Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр/	1998.04.09
13.	23	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай	2013.02.08
14.	41	Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай	2015-02-18

**Хөрөнгө оруулалтын бодлогыг зохицуулахтай холбоотой
Засгийн газрын тогтоол**

Хавсралт 3

Хөрөнгө оруулалтыг зохицуулж буй Засгийн газрын нийт 29 тогтоолын 14 тогтоол нь уг асуудлыг голлон зохицуулж байна.

№	Он дугаар	Тогтоолын нэр
1.	2012 оны № 171	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр
2.	2005 оны № 201	Бүсийн тулгуур төв хотуудыг 2020 он хүртэл хөгжүүлэх хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай
3.	2004 оны № 29	Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих тухай /захирамж/
4.	2015 оны № 66	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай

5.	2010 оны № 299	Журам батлах тухай (Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох)
6.	2008 оны № 61	Журам батлах тухай (Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг байршуулах..)
7.	2011 оны № 221	Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчийг засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах тухай журам
8.	2012 оны № 118	Давамгайлалтай хуулийн этгээд бусад хуулийн этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, өрсөлдөгчийн хувьцааг худалдан авахад дүгнэлт гаргах журам
9.	2009 оны № 287	Уул уурхай, дэд бүтцийн салбарт алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох журам
10.	2006 оны № 185	Журам батлах тухай /Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам/
11.	2006 оны №258	Журам батлах тухай /Эрсдэлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам", "Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам"/
12.	2005 оны № 39	Журам батлах тухай /Бүсийн хөгжлийг дэмжих сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих/
13.	2015 оны № 146	Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавих шаардлага, авлага барагдуулах журам
14.	2014 оны № 371	Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжих журам
15.	2013 оны № 75	Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх журам
16.	2014 оны № 222	Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам
17.	2015 оны № 295	Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журам
18.	2014 оны № 52	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам
19.	2015 оны № 296	Орон сууцны ипотекийн зээлийн баталгааны журам
20.	2007 оны № 306	Монгол Улсад үндэсний инновацийнт огтолцоог хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай
21.	2010 оны №0123	Нийтлэг журам батлах тухай (Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах)
22.	2001 оны № 125	Үзэл баримтлал батлах тухай санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал
23.	2009 оны №222	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр
24.	2008 оны №183	"Транзит Монгол" Үндэсний Хөтөлбөр

25.	2012 оны №223	Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
26.	2014 оны №278	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр (2014-2016)
27.	2007 оны 131	“Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх” хөтөлбөр
28.	2009 оны №299	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр (2009-2016)
29.	2008 оны №184	Монгол Улсыг хөгжүүлэх сангаас эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхөд 2009-2015 онд баримтлах чиглэл